



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 476

Улаанбаатар хот

Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх болон мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын номинал данс эзэмших зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.16, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 6.4, 6.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Таван богд капитал ҮЦК” ХХК-д гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх болон мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын номинал данс эзэмших зөвшөөрлийг тус тус олгосугай.

2. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх болон мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын номинал данс эзэмших зөвшөөрлийг тус тус олгосонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Таван богд капитал ҮЦК” ХХК /Г.Мөнх-Эрдэнэ/-д үүрэг болгосугай:

1/ Компанийн эрхлэх үйл ажиллагааны төрөлд орсон нэмэлт, өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, зохих өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, хувийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх;

2/ Хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон дүрэм, журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.



ДАРГА Д.БАЯРСАЙХАН

151800001145